



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/025/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Д.Оюун-Эрдэнэ
Утас: 88916603 Цахим хаяг: oyun-erdenede@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/52

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

6426050156

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

Тайлант онд Монгол улсын Засгийн газар, Холбооны бүгд найрамдах герман улсын Засгийн газар хооронд байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн хүрээнд Германы сэргээн босголтын банкаар дамжуулан Монгол улсад хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн санхүүжилтээр 24,294.2 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж ирснийг хүлээн авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		466,541,409.94	311,709,297.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		274,144,976.63	162,391,462.12
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		274,144,976.63	162,391,462.12
3121	Төгрөг		274,144,976.63	162,391,462.12
31211	Төрийн сангийн харилцах		274,144,976.63	162,391,462.12
33	АВЛАГА		-	126,145.96
335	Бусад авлага		-	126,145.96
3351	Байгууллагаас авах авлага		-	126,145.96
35	БАРАА МАТЕРИАЛ		192,396,433.31	149,191,689.25
351	Түүхий эд материал		8,929,836.56	15,731,484.58
35110	Тусгай зориулалттай материал		7,656,786.56	14,458,434.58
35130	Эм боох материал		1,273,050.00	1,273,050.00
354	Хангамжийн материал		183,466,596.75	133,460,204.67
35410	Бичиг хэргийн материал		12,393,787.16	5,583,255.08
35420	Аж ахуйн материал		144,712,809.59	101,516,949.59
35470	Бусад хангамжийн материал		26,360,000.00	26,360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		894,209,472.76	921,703,610.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		894,209,472.76	921,703,610.10
392	Биет хөрөнгө		848,039,722.76	877,408,860.10
39201	Барилга, байгууламж, орон сууц		755,874,790.36	898,247,790.36
39202	Хуримтлагдсан элэгдэл		(237,850,236.21)	(286,462,622.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		543,162,679.09	460,017,652.72
39206	Хуримтлагдсан элэгдэл		(285,368,311.05)	(255,833,344.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		135,419,723.45	115,858,315.07
39208	Хуримтлагдсан элэгдэл		(111,462,540.72)	(81,541,414.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө		32,135,100.00	32,135,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(24,849,999.96)	(25,907,019.96)
39217	Ном		40,978,517.80	20,894,404.00
393	Биет бус хөрөнгө		46,169,750.00	44,294,750.00
39301	Програм хангамж		7,300,000.00	7,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,706,250.00)	(3,581,250.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		40,576,000.00	40,576,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,360,750,882.70	1,233,412,907.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		71,165,748.00	42,498,498.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		71,165,748.00	42,498,498.00
413	Өглөг		71,165,748.00	42,498,498.00
4136	Бусад өглөг		71,165,748.00	42,498,498.00
41361	Байгууллагад төлөх өглөг		71,165,748.00	42,498,498.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,289,585,134.70	1,190,914,409.43
51	Засгийн газрын хувь оролцоо		1,289,585,134.70	1,190,914,409.43

**Баянхонгор аймгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		824,983,989.49	824,983,989.49
51101	Өмч: - төрийн		824,983,989.49	824,983,989.49
512	Хуримтлагдсан үр дүн		439,814,447.28	341,789,154.41
51210	Өмнөх үеийн үр дүн		274,992,196.50	440,459,879.68
51220	Тайлант үеийн үр дүн		164,822,250.78	(98,670,725.27)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		24,786,697.93	24,141,265.53
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,360,750,882.70	1,233,412,907.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,422,449,420.59	2,665,688,948.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		42,911,220.59	185,163,648.02
120	Нийтлэг татварын бус орлого		42,911,220.59	185,163,648.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		42,911,220.59	185,163,648.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,138,245.00	1,390,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		41,772,975.59	183,773,648.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,379,538,200.00	2,480,525,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		2,201,627,300.00	2,254,937,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,201,627,300.00	2,254,937,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		177,910,900.00	225,587,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		177,910,900.00	225,587,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		2,257,627,169.81	2,744,275,559.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,257,627,169.81	2,744,275,559.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,181,189,065.81	2,644,918,133.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,533,175,267.03	1,857,216,221.71
210101	Үндсэн цалин		943,582,562.45	1,100,614,660.00
210102	Нэмэгдэл		528,705,054.58	626,975,968.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	54,340,000.00
210104	Урамшуулал		60,887,650.00	75,285,593.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		190,298,237.92	225,036,009.06
210201	Тэтгэврийн даатгал		129,150,607.78	152,835,148.24
210202	Тэтгэмжийн даатгал		15,391,298.36	18,615,704.78
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,850,472.98	9,750,268.03
210204	Ажилгүйдлийн даатгал		7,581,172.29	8,664,666.65
210205	Эрүүл мэндийн даатгал		30,324,686.51	35,170,221.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		149,753,696.00	194,263,874.00
210301	Гэрэл, цахилгаан		11,867,090.00	14,675,860.00
210302	Түлш, халаалт		136,236,606.00	176,288,014.00
210303	Цэвэр, бохир ус		1,650,000.00	3,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		48,738,690.00	93,943,292.08
210401	Бичиг хэрэг		18,165,270.00	18,139,182.08
210402	Тээвэр, шатахуун		839,770.00	317,900.00

**Баянхонгор аймгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210404	Ном, хэвлэл		3,255,500.00	2,695,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		26,478,150.00	72,791,210.00
2105	Нормативт зардал		84,396,500.00	88,624,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		705,800.00	108,100.00
210502	Хоол, хүнс		83,690,700.00	88,516,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,417,600.00	19,887,000.00
210604	Урсгал засвар		16,417,600.00	19,887,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		29,502,254.58	26,234,537.78
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		29,502,254.58	26,234,537.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		128,906,820.28	139,712,798.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,836,440.00	10,948,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		117,070,380.28	128,763,998.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		76,438,104.00	99,357,426.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		64,698,500.00	87,920,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		64,698,500.00	87,920,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		11,739,604.00	11,436,726.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,739,604.00	11,436,726.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		<u>164,822,250.78</u>	<u>(78,586,611.47)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		-	20,084,113.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		-	20,084,113.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		-	(20,084,113.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		<u>164,822,250.78</u>	<u>(98,670,725.27)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		<u>2,380,676,445.00</u>	<u>2,481,915,300.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,138,245.00	1,390,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		1,138,245.00	1,390,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,138,245.00	1,390,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,138,245.00	1,390,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,379,538,200.00	2,480,525,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		2,201,627,300.00	2,254,937,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,201,627,300.00	2,254,937,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		177,910,900.00	225,587,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		177,910,900.00	225,587,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		<u>2,154,457,639.53</u>	<u>2,583,993,764.51</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,154,457,639.53	2,583,993,764.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,078,019,535.53	2,484,636,338.51



**Баянхонгор аймгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,533,175,267.01	1,857,216,221.71
210101	Үндсэн цалин		944,412,663.47	1,106,212,546.71
210102	Нэмэгдэл		527,888,342.54	626,365,705.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		-	54,222,226.00
210104	Урамшуулал		60,874,261.00	70,415,744.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		190,298,237.94	225,162,155.02
210201	Тэтгэврийн даатгал		130,110,981.31	153,274,355.16
210202	Тэтгэмжийн даатгал		15,105,797.54	18,340,063.29
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,549,874.14	9,501,971.75
210204	Ажилгүйдлийн даатгал		7,506,237.47	8,800,006.61
210205	Эрүүл мэндийн даатгал		30,025,347.48	35,245,758.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		149,753,696.00	194,263,874.00
210301	Гэрэл, цахилгаан		11,717,090.00	14,675,860.00
210302	Түлш, халаалт		136,236,606.00	176,288,014.00
210303	Цэвэр, бохир ус		1,800,000.00	3,300,000.00
2105	Нормативт зардал		83,690,700.00	88,516,300.00
210502	Хоол, хүнс		83,690,700.00	88,516,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		16,417,600.00	19,887,000.00
210604	Урсгал засвар		16,417,600.00	19,887,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		48,324,254.58	26,234,537.78
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		48,324,254.58	26,234,537.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		56,359,780.00	73,356,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		40,389,810.00	63,360,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		15,969,970.00	9,995,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		76,438,104.00	99,357,426.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		64,698,500.00	87,920,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		64,698,500.00	87,920,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		11,739,604.00	11,436,726.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,739,604.00	11,436,726.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		226,218,805.47	(102,078,464.51)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		21,249,252.00	9,675,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		21,249,252.00	9,675,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр		21,249,252.00	9,675,050.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		21,249,252.00	9,675,050.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(21,249,252.00)	(9,675,050.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		204,969,553.47	(111,753,514.51)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		69,175,423.16	274,144,976.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		274,144,976.63	162,391,462.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	824,983,989.49	24,786,697.93	274,992,196.50	1,124,762,883.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	824,983,989.49	24,786,697.93	274,992,196.50	1,124,762,883.92
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	164,822,250.78	164,822,250.78
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	824,983,989.49	24,786,697.93	439,814,447.28	1,289,585,134.70
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	824,983,989.49	24,786,697.93	439,814,447.28	1,289,585,134.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	645,432.40	645,432.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	824,983,989.49	24,786,697.93	440,459,879.68	1,290,230,567.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(645,432.40)	-	(645,432.40)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(98,670,725.27)	(98,670,725.27)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	824,983,989.49	24,141,265.53	341,789,154.41	1,190,914,409.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,562,812,400.00	2,530,472,676.63	32,339,723.37	98.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,292,062,100.00	2,254,937,700.00	37,124,400.00	98.4
Улсын төсвөөс санхүүжих	2,292,062,100.00	2,254,937,700.00	37,124,400.00	98.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	270,750,300.00	275,534,976.63	(4,784,676.63)	101.8
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,140,000.00	1,390,000.00	(250,000.00)	121.9
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	269,610,300.00	274,144,976.63	(4,534,676.63)	101.7
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,562,812,400.00	2,368,081,214.51	194,731,185.49	92.4
УРСГАЛ ЗАРДАЛ	2,562,812,400.00	2,368,081,214.51	194,731,185.49	92.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,468,229,200.00	2,280,160,514.51	188,068,685.49	92.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,976,512,100.00	1,857,216,221.71	119,295,878.29	94.0
Үндсэн цалин	1,267,936,800.00	1,106,212,546.71	161,724,253.29	87.2
Нэмэгдэл	669,134,100.00	626,365,705.00	42,768,395.00	93.6

**Баянхонгор аймгийн Богд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Унаа хоолны хөнгөлөлт	-	54,222,226.00	(54,222,226.00)	
Урамшуулал	39,441,200.00	70,415,744.00	(30,974,544.00)	178.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,158,100.00	225,162,155.02	21,995,944.98	91.1
Тэтгэврийн даатгал	168,067,400.00	153,274,355.16	14,793,044.84	91.2
Тэтгэмжийн даатгал	19,772,700.00	18,340,063.29	1,432,636.71	92.8
ҮОМШӨ-ний даатгал	9,886,400.00	9,501,971.75	384,428.25	96.1
Ажилгүйдлийн даатгал	9,886,400.00	8,800,006.61	1,086,393.39	89.0
Эрүүл мэндийн даатгал	39,545,200.00	35,245,758.21	4,299,441.79	89.1
Нормативт зардал	121,042,500.00	88,516,300.00	32,526,200.00	73.1
Хоол, хүнс	121,042,500.00	88,516,300.00	32,526,200.00	73.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,743,800.00	26,234,537.78	3,509,262.22	88.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,743,800.00	26,234,537.78	3,509,262.22	88.2
Бараа үйлчилгээний бусад зардал	93,772,700.00	83,031,300.00	10,741,400.00	88.5
Бараа үйлчилгээний бусад зардал	83,592,800.00	73,035,900.00	10,556,900.00	87.4
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,179,900.00	9,995,400.00	184,500.00	98.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,583,200.00	87,920,700.00	6,662,500.00	93.0
Бусад урсгал шилжүүлэг	94,583,200.00	87,920,700.00	6,662,500.00	93.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,583,200.00	87,920,700.00	6,662,500.00	93.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	274,144,976.63		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	162,391,462.12		

Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	225,587,600.00	214,150,900.00	11,436,700.00	94.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	225,587,600.00	214,150,900.00	11,436,700.00	94.9
Орон нутгийн төсвөөс	225,587,600.00	214,150,900.00	11,436,700.00	94.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	225,587,600.00	214,150,874.00	11,436,726.00	94.9
УРСГАЛ ЗАРДАЛ	225,587,600.00	214,150,874.00	11,436,726.00	94.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	225,587,600.00	214,150,874.00	11,436,726.00	94.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,587,600.00	194,263,874.00	11,323,726.00	94.5
Гэрэл, цахилгаан	16,000,000.00	14,675,860.00	1,324,140.00	91.7
Түлш, халаалт	186,287,600.00	176,288,014.00	9,999,586.00	94.6
Цэвэр, бохир ус	3,300,000.00	3,300,000.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,887,000.00	113,000.00	99.4
Урсгал засвар	20,000,000.00	19,887,000.00	113,000.00	99.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Богд сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэлийн болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах
- Багш бүр сургалтын амжилтаа ахиулах
- Багш бүр ээлжит хичээлийн хөтөлбөрийг чанартай боловсруулж, бусад багш нартай туршлагаа түгээх
- Сургуулийн өмнөх болон шинэчилсэн хөтөлбөрийг судалж цэцэрлэгийн багш нартай хамтарч ажиллах
- "Өдөр бүр сүү" хөтөлбөрийг эцэг эхийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх
- "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд сурагчдын шүдийг эмчлүүлэх
- Математик, Монгол хэл бичгийн хичээлийн массын олимпиадыг зохион байгуулж, амжилтаа ахиулах
- "Eduten", "Pearson" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ахицыг нэмэгдүүлэх
- Ном уншлагын цагийг тогтмолжуулж, анги бүр номын сантай болох

Богд сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар захиргаа аж ахуй, байгалийн ухаан, нийгмийн ухаан, бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттай, 72 орон тоотой ажиллахаас, 61 орон тоотой ажиллаж, бага ангийн 10, ахлах ангийн 12 нийт 22 бүлэгт 554 сурагч, дүйцсэн хөтөлбөрт 26 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол улсын засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолоор цалин хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Боловсролын ерөнхий газрын дотоод аудитын нэгж хэрэгжүүлдэг ба тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар журмууд, УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 127,338.0 мянган төгрөг буюу 9.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	466,541.41	311,709.30	(154,832.1)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	274,145.0	162,391.5	(111,753.5)
Авлага	-	126.1	126.1
Бараа материал	192,396.4	149,191.7	(43,204.7)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	894,209.5	921,703.6	27,494.1
Үндсэн хөрөнгө	1,555,446.8	1,575,029.3	19,582.5
Хуримтлагдсан элэгдэл	(661,237.3)	(653,325.7)	7,911.7
Нийт хөрөнгө	1,360,750.9	1,233,412.9	(127,338.0)
Өр төлбөр	71,165.7	42,498.5	(28,667.3)
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн	1,289,585.1	1,190,914.4	(98,670.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,360,750.9	1,233,412.9	(127,338.0)

Дээрх хүснэгтээс харахад Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, засгийн газрын хувь оролцоо дансуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 162,391.5 мянган болж өмнөх оноос 111,753.5 мянган төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс 2,254,937.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 1,390.0 төгрөг төвлөрч үйл ажиллагааны зардалд 2,582,232.1 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна. Үүнээс 214,150.9 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлсэн бөгөөд тогтмол зардалд 194,263.9 мянга, урсгал засварын зардалд 19,887.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 230,064.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 17,106.4 мянган төгрөгийн бараа үнэ төлбөргүй орлого авч, нийт 232,239.2 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, 58,136.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассантай холбоотойгоор бараа материалын үлдэгдэл 43,204.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд тайлант онд Монгол улсад хэрэгжиж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн санхүүжилтээр 24,294.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 9,675.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн “Хөрөнгө акталж, данснаас хасах тухай” 7/42 дугаар тогтоолоор цаашид ашиглах боломжгүй 156,759.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, сумын ОНХС-ийн санхүүжилтээр сургуулийн спорт зааланд 142,373.0 мянган төгрөгийн засвар хийгдэж сайжруулалтаар бүртгэсэн байна.

Өглөгийн үлдэгдэл 42,498.5 мянган төгрөг нь 2024 онд цахим ангийн тоног төхөөрөмж зээлээр худалдан авсантай холбоотой бөгөөд тайлант онд гэрээний дагуу төлөх 21,249.3 мянган төгрөгийг төлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,190,914.4 мянган төгрөг болж 98,670.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous санхүүгийн программыг 2008 оноос хойш ашиглаж байгаа бөгөөд санхүүгийн тайланд 300.0 мянган төгрөгийн өртөгтэй, мөн 300.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй байна. Программ хангамжтай холбоотойгоор тайлант онд 341.0 мянган төгрөгийн зардал урсгал зардлын төсвөөс зарцуулагдсан байна.

Газар эзэмших, ашиглах эрхийн байдал

Тус байгууллагад 20,288 м² талбай бүхий эзэмших эрхтэй 5 газрыг 2011 онд 15 жилийн хугацаатай эзэмшүүлж, гэрчилгээг олгосон байна. Газартай холбоотой бүртгэл тайлангийн мэдээлэл нь газар эзэмших эрхийн гэрчилгээ болон цахим санд (egazar.gov.mn) дахь мэдээлэлтэй тохирч байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,151,726.3 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зардлыг 176,055.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,327,781.4 мянган төгрөгөөр баталж өгсөн байна.

Төсвийн төслийг 2025 оны 12 дугаар сард тодотгон 235,031.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,562,812.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тус төсөвт ажилчдын цалин хөлс болон бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлж өгсөн байна.

Орон нутгийн төсвөөс тогтмол зардал болон урсгал засварын зардлыг 225,587.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,562,812.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,368,081.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Орон нутгийн төсвөөс 225,587.6 мянган төгрөгийн санхүүжилт авч 214,150.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 11,436.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт (хувь)
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	2,946.6	2,946.5	0.1	100.0
80223	Хүүхэд хамгаалал	3,466.4	1,467.9	1,998.5	42.3
80312	сургалт семинар	2,585.3	880.0	1,705.3	34.0
81605	Эрүүл мэндийг дэмжих	2,992.9	2,990.0	2.9	99.9
81801	Үдийн цай хөтөлбөр	94,583.2	87,920.7	6,662.5	93.0
81806	Дотуур байрны үйлчилгээ	547,370.7	452,015.3	95,355.4	82.6
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	38,342.3	38,342.3	0.0	100.0
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	11,436.1	4,586.0	6,850.1	40.1
81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	39,168.2	25,080.0	14,088.2	64.0
81834	Боловсролын стандарт, сургалты	1,772,780.0	1,712,853.4	59,926.6	96.6
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	33,723.9	26,954.0	6,769.9	79.9
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	1,991.5	1,991.5	0.0	100.0
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	11,425.3	10,053.6	1,371.7	88.0
Нийт		2,562,812.4	2,368,081.2	194,731.2	92.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

1. Байгууллагын орон тооны цомхотгол: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дугаар хамтарсан тушаалаар "Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг тогтоож өгсөн байна. Тус байгууллага нь Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар захиргаа аж ахуй, байгалийн ухаан, нийгмийн ухаан, бага ангийн заах аргын нэгдэл гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар, 72 орон тоотой ажиллахаас, 61 орон тоотой ажилласан, багшийн орон тооны дутагдалтай байна. Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлт (2100103)-ийн зардал: Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам", Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн Богд сумын ЕБС-ийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/10 дугаар тушаалаар багш, ажилчдад нэг өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож хоолны хөнгөлөлт олгож эхэлсэн байна. Тайлант онд хоолны хөнгөлөлтийн зардалд 54,222.2 мянган төгрөгийг цалин хөлсний төсөвтөө багтаан олгосон байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал: 2025 онд 3 арга хэмжээ зохион байгуулахаар, нийт 2,385.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 1 арга хэмжээ зохион байгуулж 1,000.0 мянган төгрөг зарцуулсан байна. 2025 оны 12 дугаар сард эцэг эх, асран хамгаалагчдад "Хүүхэд хамгаалал-Хүмүүжлийн эерэг арга" сэдэвт сургалт, сурагчдад "Өөрийгөө хайрлах нь бусдыг хайрлахаас эхэлдэг" сэдэвт сургалт тус тус зохион байгуулж, сургуулийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/61 дугаар тушаалын дагуу хүүхэд хамгааллын зардлаас сургалтын зардлыг санхүүжүүлсэн байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нийт 248,273.9 мянган төгрөгийн, дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд 144,158.2 мянган төгрөг, сурагчдын үдийн цайнд 104,115.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар зохион байгуулж сонгон шалгаруулалт явуулахаар төлөвлөсөн байна.

Дээрх төсөвт өртөг бүхий 2 худалдан авах ажиллагааг тус бүр 4 багцтай тендер шалгаруулалт зохион байгуулахаар 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр tender.gov.mn цахим системд тендерийн баримт бичгийг байршуулж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулсан байна. Тайлант онд дотуур байрны хоол хүнсний зардалд 88,516.3 мянган төгрөг, үдийн цайны зардалд 87,920.7 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт өртгөөс нийт 71,836.9 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын

сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 139 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 2,788,400.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,884.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн тайлангийн түвшинд газар эзэмших, ашиглах эрхийн байдалтай холбоотой 1 эрсдэлийг нэмж тодорхойлон, холбогдох горим сорилыг гүйцэтгэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 51 гүйлгээний 2,915,646.9 мянган төгрөгийн санхүүжилтийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Шилэн дансны дэлгэрэнгүй мэдээлэл буюу байгууллагын ерөнхий мэдээлэл дэх мэдээлэл, үнэн зөв, бүрэн гүйцэт, бусад бүх мэдээллийг хугацаанд нь байршуулж ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар зөрчил илрээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1,544.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлсэн.

Хүснэгт 3. Албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	1,544.0	2	1,544.0	100%
Нийт дүн	2	1,544.0	2	1,544.0	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн анхаарах асуудлын дагуу нягтлан бодогчид балансын урамшуулал олгосон эсэхийг шалгахад Боловсролын сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/277 тоот тушаалыг үндэслэн Баянхонгор аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Урамшуулал олгох тухай” А/27 дугаар тушаалаар 1 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал авсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй математик, англи хэлний хичээлийн программын үйлчилгээний төлбөрт тайлант онд 10,053.6 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн сарын динамик мэдээний программын төлбөрт 160.0 мянган төгрөг, боловсролын нэгдсэн системийн esis.edu.mn/hr/ программын төлбөрт 7,476.0 төгрөгийг тус тус төлж байгаа асуудлыг дээд шатны захирагч анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----